



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/55

Онги

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрийн “Гүүрний баруун талд” байршилтай Санжид овогтой Мөнхжаргал (ЗЛ85032110)-ийн жимс, жимсгэний усалгаатай тариалангийн газрын зориулалттай 5000 м.кв (0.5 га) газрыг Цэцэгмаа овогтой Урангэрэл (ЗЛ86040402)-д зориулалтын дагуу шилжүүлэн 19 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг шинэчлэн олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн (Т.Саранзул)-д үүрэг болгосугай.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч (Ц.Урангэрэл)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2012 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 74 дугаар захирамж мөн газар эзэмших эрхийн 0391617 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЛУВСАНРАГВА